

МАНДАЛ ДААТГАЛ ХК-НИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.6 дугаар зүйл, Мандал даатгал хувьцаат компанийн дүрмийн 8.14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн мөн Мандал Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 сарын 19-ний өдрийн хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Мандал даатгал ХК нь 2023 онд 5,8 тэрбум төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан, ТУЗ-өөс компанийн санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, 2024 оны бизнес төлөвлөгөө стратегийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг олгохгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- Компанийн тухай хуулийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн энэхүү шийдвэрийн үндэслэлийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг гүйцэтгэх захирал Ж.Батчимэгт даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2024 оны 02-р сарын 19-ний өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн Компанийн тухай хуулийн 80.2 болон Компанийн дүрмийн 8.16-г тус тус үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ